

БАТЛАВ.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ГАНСҮХ



АЖЛЫН БАЙРНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ
ЯПОН МЕНЕЖМЕНТ-5S СТАНДАРТЫГ
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМАНД НЭВТРҮҮЛЭХ УДИРДАМЖ

Үндэслэл

Төрийн албаны тухай хуулийн “38.1.3-д “цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатны албан хаагчид бичгээр тавих”; 61.1.2-т “албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах” гэж тус тус төрийн албан хаагчийн нийтлэг эрх, баталгааг заасан.

Яамны албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаагаар албан хаагчид “Өрөө тасалгаандаа олуулаа суудаг тул хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлдөг. Ажиллах орчин хүртээмжгүй, эрүүл бус, анхаарал төвлөрөх, юм уншиж ойлгох боломж байдаггүй” гэсэн үр дүн гарсан.

Ялангуяа Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар болон бусад газруудын албан хаагчдын өрөөний эрүүл ахуйн хэмжилтээр стандартын шаардлага хангахгүй нь тогтоогдсон тул өрөөний зохион байгуулалтыг оновчтой хийх нэн шаардлагатай байна.

Иймд Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо шаардлага ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх хүрээнд ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах Япон менежмент -5S стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэхдээ дараах журам, чиглэлийг баримтална. Үүнд:

Нэг. Зорилго

1.1. Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний ажиллах нөхцлийн талаарх сэтгэл ханамж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, цаг хугацааг хэмнэх.

Хоёр. Зорилт

2.2. Яамны ажлын байран дахь эмх цэгц, аюулгүй байдлыг сайжруулах 5 S стандартыг ажлын байранд нэвтрүүлж, мөрдөх /нүдэнд ил харагдах биет зүйлсийн эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах/;

2.3. Яамны ажлын байрны эмх цэгцийн хуваарьт ба урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээний стандарт боловсруулан мөрдөх */Графикт үзлэг үйлчилгээг тогтмолжуулан сайжруулах/*.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Яамны хэмжээнд ажлын байрны эмх цэгцийг бүрдүүлэх 5S стандартыг нэвтрүүлэх аяныг 2022 оны 8 дугаар сарын 18-25-ны өдрүүдэд зохион байгуулах;

3.2. Баг аяныг дүгнэх үнэлгээний шалгуур үзүүлэлтийг мөн албан хаагчдад танилцуулах;

3.3. Баг аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудыг шалгуур үзүүлэлтийн дагуу оноогоор 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдөр дүгнэж, Шилдэг хамт олон, Шилдэг албан хаагчийг шалгаруулан, урамшуулах;

3.4. Урамшуулалд тус бүр Өргөмжлөл, 150,000.0 /Стандартын зөвлөх баг, Чанарын менежментийн баг/ төгрөг байна.

Дөрөв. Хариуцлага, хамтын ажиллагаа

4.1. Яамны газар, хэлтсийн удирдлага Чанарын менежментийн багтай хамтран дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

4.2. Хэрэгжилтийг хангуулах чиглэлд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажиллах;

4.3. Энэхүү удирдамжийн зорилтыг хэрэгжүүлээгүй, 3.4-т заасан аянд хамрагдаагүй ба хангалтгүй хамрагдсан албан тушаалтан, албан хаагчийн 2022 оны хагас жилийн ажлын үр дүнгийн үнэлгээг бууруулах үндэслэл болно.

-----***-----